



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Газрын дүрмийн 7.1.1, Хөдөлмөрийн дотоод журмын 2.2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг байгууллагын хэмжээнд мөрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдуулан гаргасан иргэн, хуулийн этгээдийн гомдол мэдээллийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх эсэх талаар дүгнэлт гаргах эрх бүхий Ёс зүйн дэд хороог хавсралтаар байгуулсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж, “Төрийн албаны төв байгууллага”-ын дэргэдэх Ёс зүйн хороонд тайлагнаж ажиллахыг Ёс зүйн дэд хороо (Э.Даваахатан)-д үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ